



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 1/03

Цагаан-Уул сум

Г Гал түймрийн аюул, гол нуурын мөс
цөмрөх ослоос урьдчилан сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын төвд айл өрхүүдийн хашаанд хураалттай байгаа өвс тэжээлийг фондын хашаанд төвлөрүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх, албан байгууллага аж ахуйн нэгж, айл өрхүүдэд тог цахилгааны утасны бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааны зааварчилгаа зөвлөмж өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Г.Жанчивдорж (Гал түймэр унтраах аврах 73 дугаар ангийн захирагч)

Гишүүд: А.Энхбаяр (Хэсгийн төлөөлөгч)

Х.Батнасан (Агар багийн Засаг дарга)

Д.Сандагсүрэн (Өвгөд багийн Засаг дарга)

Н.Доржпалам (Тосон багийн Засаг дарга)

Б.Ганболд (Хужирт багийн Засаг дарга)

Б.Бямба-Эрдэнэ (Шарга багийн Засаг дарга)

О.Дашбямба (Жаргалант багийн Засаг дарга)

Э.Лхагвадэмбэрэл (Байгаль хамгаалагч)

О.Батзаяа (Эрчим хүчний монтер)

Нарийн бичгийн дарга: Б.Батхишиг (Салаан захирагч)

2. Баяннуур, Дөрөлжийн нуур зэрэг авто зам дагуу нуурын орчимд анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байршуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Жанчивдорж)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

ОРЛОГЧ ДАРГА

Н.АЛТАНБААТАР

/Zahiramj 2025/